

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

2024.03 CAP



РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ



УЛАМЖЛАЛТ ХАНДЛАГА БА ЁС ЗҮЙГЭЭ ДЭЭДЛЬЕ

ҮУПК-ийн Үйлчилгээний тэнхимээс зохион байгуулж байгаа Уламжлалт хандлага ба ёс зүй "үйл ажиллагааны хүрээнд гоо заслын багш М.Нэргүй, П.Мөнхжаргал, Ё.Алтанцэцэг, С.Энхчимэг нар "Мэндлэх хүндлэх ёс зүй" уулзалт ярилцлага 1,2 күрсийн 70 гаруй суралцагчдад амжилттай зохион байгууллаа

Илтгэлийн уралдаан зохион байгуулагдлаа

Багшийн хөгжил, инновацийн төвөөс "Багшийн хөгжил- багш ажлын байран дээр хөгжих нь" сэдвийн хүрээнд илтгэлийн уралдааныг зохион байгууллаа.

- НББ-ын багш Б.Анхбаяр "Багш сургалтын хэрэглэгдэхүүнээр хөгжих нь" сэдвээр 1-р байр
- Химийн багш Да.Солонго "Багшийн ажлын байран дээрх тасралтгүй хөгжил ба хэлбэрдэх үзэгдэл" сэдвээр 2-р байр, оёдлын багш Г.Жаргалсайхан "Багшийн тасралтгүй хөгжил, явцын шалгалтын анализ" МТ-ийн багш Д.Дулаанцэцэг " Excel програмын Macro ашиглалтын судалгаа", физикийн багш М.Ганцацрал "Багшийн хөгжил- ажлын байран дээр хөгжих нь / хувь хүний сэтгэл зүйн зан төлөв дээр/ сэдвүүдээр тус тус амжилттай оролцлоо





МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ-2024

МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН
ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ-2024 чуулганы
үйл ажиллагаа 5 салбар
хуралдаанаар үргэлжилж
Боловсролын салбарын хүний
нөөцийн хөгжил ба цахим технологи"
салбар хуралдааны үр дүнг
танилцуулахаар Ч.Эмүжин
сонгогдож, салбар хуралдаанд
оролцсон боловсролын салбарын
100 гаруй төлөөллийн хамтын
ажиллагааны үр дүнг тайлагнаж,
өөрийн үзэл бодлыг илэрхийллээ

Танилцах аялал хөтөлбөр

УУПК, Жамогранд трэйвэл ХХК сүлжээ
байгууллагатай хамтран ажиллах хамтын
ажиллагааны хүрээнд мэргэжлийн ангийн
суралцагчдыг үйлдвэрлэлийн орчинтой
танилцуулан, салбарын сүүлийн үеийн дэвшилтэт
технологид суралцуулах, тэдний мэргэжлийн хүсэл
сонирхол, идэвхийг өрнүүлэх, ажлын байраар
хангагдахад зорилгоор байгууллагатай танилцах
аялал хөтөлбөрийг хамтран зохион
байгууллаа. Энэхүү аялал хөтөлбөрт Зочид буудал
жуулчны баазын үйлчилгээний ажилтан, Төлбөр
тооцоо цалин хөлсний нягтлан бодох бүртгэлийн
ажилтан Нарийн бичгийн дарга бичиг хэргийн
ажилтан Хоол үйлдвэрлэлийн технологич
мэргэжлийн ангийн нийт 46 оюутан хамрагдаж,
мэргэжлийн багш нар нийгмийн түншлэлийн арга
зүйч нар хамтран хариуцан ажиллалаа.
Аялал хөтөлбөрийн хүрээнд Terelj Hills lodge
жуулчны баазын байгууллагын үйл ажиллагаа, соёл,
ажлын байранд тавигдах шаардлагатай
танилцаж ажлын байран дээрх сургалтад
хамрагдаж, ажлын байраар хангагдах боломжоор
хангагдлаа.





Уулзалт зохион байгууллаа.

Сувдан тамир электрик” ХХК-ы захирал Ганболд, ерөнхий инженер Ганзориг нар Мехатроник болон Цахилгаанчин мэргэжлийн ангийн оюутан суралцагчидтай ажил мэргэжлийн чиг баримжаа олгох уулзалтыг зохион байгууллаа.

ус уулзалтын хүрээнд суралцагчдыг ажлын байранд цалинтай дадлагажуулах, төгсөгчдийг ажлын байраар хангах, дадлагын сургалтыг үйлдвэрт явуулах, хичээлийн бус цагаар мэргэжлийн чиглэлээр ажиллуулах зэрэг олон олон боломжийг бүрдүүлсэн үр дүнтэй уулзалт боллоо

Энтрепренер эмэгтэйчүүд-IV

Энтрепренер эмэгтэйчүүд-IV Асуудлаа шийд, амжилтад тэмүүл”эмэгтэйчүүдийн чуулга уулзалтанд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн нийгмийн түншлэлийн албаны арга зүйч нар оролцогч болон зочдод сургуулиа танилцуулан ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллах болон гэрээ байгуулан оюутан суралцагчдад ажлын байрны санал авч амжилттай оролцлоо



Монгол уламжлалт ёс заншил ба ёс суртахууныг сурталчилан таниулах, төлөвшүүлэх зорилгоор ардын зүйр цэцэн үг, цээрлэх ёсонд тулгуурласан хандлага төлөвшлийн агуулга бүхий ханын сонин гаргах “УЛАМЖЛАЛТ ХАНДЛАГА ба ЁС ЗҮЙ” уралдааныг суралцагчдын дунд зохион байгууллаа

Нийт 19 ангийн бүтээлээс:

Тэргүүн байр – Үнэт эдлэлийн дархан 1а анги

Дэд байр –НБДХА 2а анги

Гутгаар байрт-БДЗУ 1а анги хамт олны бүтээл шалгарлаа

Сургалт зохион байгуулагдлаа

Амжилт 800”номын зохиолч Буман гэрэл “ сургалтын төвийн багш Д.Мөнхцэцэг, АШУУИС- НЭМС -н багш” Буман гэрэл” сургалтын төвийн багш А. Ган-эрдэнэ Дэлхийн зөн ОУТББ- н сургагч багш Д. Шижирээ нар “ Мэргэжил сонголт ба ЭЕШ-нд хэрхэн амжилттай бэлдэх вэ? Сэдэвт лекцийг МБС-н 2-р ангийн суралцагчдад зохион байгууллаа





ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦОВ:

Монголын ууган үйлдвэрүүдийн нэг “Говь” ХХК-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор мэргэжлийн 20 багшийг хамруулан үйлдвэрийн орчин сүүлийн үеийн дэвшилтэд технологи болон шинэ бүтээгдэхүүнтэй танилцан туршлага солилцож, үйлдвэрийн удирдлагуудтай цаашдын хамтын ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцлоо

Сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа

Бүгд Найрамдах Чех Улсын элчин сайдын орлогч Лукаш Янечек сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа



Сургалт зохион байгуулагдлаа.

Ёс зүйн аяны хүрээнд Удирдлагын акедимийн Төрийн инноваци хөгжлийн албаны дарга П.Бямбасүрэнг урьж “Эерэг хандлага төрүүлэх нь EQ” сэдэвт сургалтыг нийт багш, ажилтнуудад зохион байгууллаа



Чөлөөт ярилцлага болов.

ОУУБИС-ийн Солонгос хэлний багш, доктор Б. Ариунбаатар Солонгос хэлийг содон аргаар сурч, хэрэглээнд оруулах талаар 1+1 хөтөлбөрийн мэргэжлийн ангийн оюутнуудтай чөлөөт ярилцлага хийж сургалт явууллаа

